



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 62

Улаанбаатар хот

“Улаанбаатар смарт карт” ХХК-ийн  
талаар авах зарим арга хэмжээний  
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын нийтийн зорчигч тээврийн салбарт үүссэн алдагдлыг бууруулах, төлбөр тооцооны системийг сайжруулах ажлын хүрээнд “Улаанбаатар смарт карт” ХХК-ийг үүсгэн байгуулагч Бүгд Найрамдах Солонгос Улсын “Ти-мони” компанийн эзэмшлийн 55 хувийг нийслэлийн өмчид шилжүүлэн авах хэлцэл хийж, үр дүнг танилцуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат), Засаглал, эрх зүйн шинэтгэлийн хороо (Н.Баярчимэг)-нд тус тус даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН